

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БОЛОН
ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 13

1. *Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/*

5 – 13

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын
10 дугаар сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 54 гишүүнээс 34 гишүүн хүрэлцэн ирж, 63.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Мөнхсоёл, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг;

Чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Батжаргал, Ч.Лодойсамбуу, Ч.Номин, С.Цэнгүүн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ж.Ганбаатар, Б.Тулга;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Булгантуяа, Б.Жавхлан, Б.Жаргалан, З.Мэндсайхан, Д.Пүрэвдаваа, Б.Түвшин, О.Цогтгэрэл.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Гаалийн ерөнхий газрын дэд дарга Г.Энхтайван, мөн газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, Монголбанкны Мөнгөний бодлогын хэлтсийн захирал Н.Ургамалсүвд, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч Ж.Өлзийсайхан, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Х.Шижирмөнх, М.Мандхай, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал, С.Төрмөнх, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны референт Б.Одмандах нар байлцав.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Л.Соронзонболд, Б.Пунсалмаа нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Монголбанкны Мөнгөний бодлогын хэлтсийн захирал Н.Ургамалсүвд, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 22 минут үргэлжилж, 54 гишүүнээс 35 гишүүн хүрэлцэн ирж, 64.8 хувийн ирцтэйгээр 14 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
13 цаг 41 минут

ТӨСВИЙН БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 63.0 хувьтай бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хамтарсан хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Цэндийн Баатархүү, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Далайн Батбаяр, Ринчиндоржийн Батболд, Отгоншарын Батнайрамдал, Жамбын Батсуурь, Нацагдоржийн Батсүмбэрэл, Пүрэвийн Батчимэг, Жадамбаагийн Баясгалан, Хөххүүгийн Болормаа, Шинэбаярын Бямбасүрэн, Гомбын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Батжаргалын Заяабал, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандухай, Пүрэвбаатарын Мөнхтулга, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Ганбатын Очирбат, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Ганзоригийн Тэмүүлэн, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Баттогтохын Чойжилсүрэн, Дашцэрэнгийн Энхтүвшин, Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын гишүүд оролцож байна. Хүрэлцэн ирсэн байна.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр өргөн мэдүүлсэн. Гурав дахь хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

**Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн,
гурав дахь хэлэлцүүлэг/**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Ажлын хэсгийн нэрс. Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Гэлэгжамцын Энхтайван Гаалийн ерөнхий газрын дэд дарга, Нанжидын Ургамалсүвд Монголбанкны Мөнгөний бодлогын хэлтсийн захирал, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Жамбалбавуугийн Өлзийсайхан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын шинжээч, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Сангидоржийн Баярмаа Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.3-д гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган, төслийн эцсийн хувилбарыг бэлтгэн танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасны дагуу саналыг төсөлд нэмж тусган Та бүхэнд тараасан болно.

Зарчмын зөрүүтэй саналыг төсөлд нэмж тусгасан төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга. Тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе.

Төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбоотой тоонууд өөрчлөгдөөд 2026 он дээр засварууд ороод ирсэн байна.

Тэгээд энэ дээр шалтгааныг нь нэгдсэн байдлаар танилцуулах ёстой байсан юм биш үү? Юун дээр танилцуулга авмаар байна гэвэл хэрэглээний үнийн өсөлтийн түвшнийг бид нар яг анх засгаас орж ирсэн хувилбар дээр 7 байсан. Одоо болохоор 7.5 болж өгсөж орж ирж байгаа юм байна. Үүний үндсэн шалтгааныг тайлбарлаад өгөөч?

Хэрвээ одоо ингэж өсөж байгаа бол төсвийн төсөөлөл 2027, 2028 онуудад бас өөрчлөгдөх ёстой байсан биш үү?

Тэгээд хоёрдугаар нэг зүйл нь өнөөдөр Нийгмийн бодлого, Төсөв хоёрын хамтарсан хуралдаан дээр нэлээн яригдах шиг болсон. Тэтгэвэр болон цалинтай холбоотой асуудлууд.

Хэрвээ тэр урсгал зардал дээр өөрчлөлт ороод 2026 оны анх өргөн баригдсан төсвийн хүрээний мэдэгдэл дээр өөрчлөлт орохоор болбол. Орсон байгаа байдал нь энэ юм уу? Эсвэл дараа нь дахиж өөрчлөлт орох юм уу? Ийм хоёр зүйл дээр хариулт авъя.

Р.Сэддорж: Хариулт. Гараа өргөөрэй. 4 номер.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү. Б.Уянга гишүүний асуултад хариулъя.

Орлого зарлагыг 490.0 тэрбумаар нэмэгдүүлж байгаатай холбоотой урсгал зардлын өсөлт нь өөрөө инфляцад шууд нөлөөлнө.

Энэ тооцооллыг хийсэн. Нөлөөллийг нь тусгахаар 2026 оны инфляцын зорилтот түвшин 7.5 болж дээшээ нэмэгдэхээр тоо гарч байгаа.

Сая Байнгын хороон дээр хэлэлцэгдсэн асуудлыг энэ дээр би хэлж, хариулж болохгүй байгаад байна.

Саяын зарлага өсгөж байгаагийн тооцооллыг оруулахаар инфляцын түвшин 7-гоос 7.5 болж нэмэгдэхээр байгаа юм.

Р.Сэддорж: Үргэлжлүүлж нэмж хариулъя. 4 номер.

И.Батхүү: Ажлын хэсэг сая Байнгын хороог хүлээж байгаад нөгөө Байнгын хороонд хэлэлцэгдсэн асуудал Байнгын хороо хоорондоо асуудлаа ярих ёстой байх. Ажлын хэсэг дээр тэр тооцоолол яригдаагүй шүү дээ.

Р.Сэддорж: Б.Пунсалмаа гишүүнийг нэмье. Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд асуулт асууя.

Л.Соронзонболд: Өмнөх нэгдсэн хуралдаан дээр Б.Мөнхтуяа гишүүний дэвшүүлсэн 490.0 тэрбум төгрөгийн санал чинь гол нь Нийгмийн бодлогын байнгын хороогоор дэмжигдээгүй.

Тэгээд Их Хурал дээр ирц хангалтгүй байсан учраас бас дэмжигдээгүй гээд ингээд гараад ирсэн санал байгаа л даа.

Тэгэхээр би ойлгохдоо Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультайгаа уялдаад бодоод үзэхээр энэ 490.0 тэрбум төгрөгөөр уг нь нэмэх үндэслэл байхгүй асуудал байсан юм билээ.

Тэгэхээр үүнийг цаашдаа нэгдсэн хуралдаанаар орохдоо ямар байдлаар шийдвэрлэх юм бэ гэдэг дээр Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооноос тодорхой шийдвэр гаргах нь зөв болов уу гэсэн саналтай байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг авч хэлэлцэж эргэж хэлэлцэж болох тухай яригдсан.

Тэгэхээр энэ дээр нэг тайлбар өгөөч. Манай Эдийн засгийн байнгын хорооны зөвлөхүүд.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүний асуултад ажлын хэсгийн микрофон. Ажлын албаны микрофон.

Д.Мягмарцэрэн: Эдийн засгийн байнгын хорооны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн байна. Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.5 дээр нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлгийг явуулахад хамтарсан хуралдааны танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан санал Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Төсвийн тусгай шаардлага хангагдаагүй нөхцөл үүссэн тохиолдолд тодорхой асуудлаар чиглэл өгч, хоёрд дахь хэлэлцүүлгийг дахин явуулахаар төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодод төслийг буцааж болно гэсэн зохицуулалт байгаа.

Тэгэхээр нэгдсэн хуралдаан дээр энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой гэсэн үг.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Тэгэхээр одоо 3 дугаар хэлэлцүүлгийн дараагаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэрвээ дүгнэлтээ тусгай шаардлагад нийцсэн байвал, үгүй юу гэдэг дээр дүгнэлт гаргах гээд байна шүү дээ.

Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс асууж болох уу? Тэгвэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс энэ тал дээр тодорхой ажиллаж байгаа асуудал байгаа юу гэж.

Р.Сэддорж: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн. 1 номер дээр.

Ж.Дэлгэрсайхан: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан.

Сая зөвлөхийн уншсан заалт бол яах аргагүй байгаа. Бид гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө яг одоо энд яригдаж байгаа зарчмын зөрүүтэй саналтай холбоотой орж ирж байгаа өөрчлөлт нь хэрвээ хийгдвэл төсвийн тусгай шаардлага, төсвийн төсвийн тусгай шаардлагыг хангасан эсэх дээр яах аргагүй дэгийн тухай хуулийн дагуу дүгнэлт гаргана.

Өнөөдрийн нөхцөл байдалд бид яг энэ асуудал дээр өчигдөр хуралдаж ярилцаж байна. Мөн өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гарах шийдвэрийг гарсны дараа бид энэ дээр дүгнэлт гарна.

Үр дагаврын хувьд хэрвээ нөхцөл байдлаас хамаараад төсвийн тусгай шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гарах ийм нөхцөл үүсэх юм бол дэгийн тухай хуулийн дагуу энэ буцах нөхцөл байдал үүснэ гэсэн ийм хариултыг өгмөөр байна.

Р.Сэддорж: Гүйцээж хариулъя. 1 номер.

Ж.Дэлгэрсайхан: Учир нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1.5-д зааснаар үнэхээр Төсвийн тогтвортой байдлын 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагад нийцээгүй гэсэн дүгнэлт гарах нөхцөл байдал үүсэх юм бол төсвийн хоёр дахь хэлэлцүүлэг рүү дахин буцаах ийм үр дагавартай байх магадлалтай гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: 9 номер.

М.Санжаадорж: Сангийн яам. М.Санжаадорж. Л.Соронзонболд гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье.

Саяын энэ ярьж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдээд батлагдсан тохиолдол юу болох вэ гэхээр үр дагавар талаас нь ярих юм бол орлого зарлага хоёр хоёулаа зэрэг нэмэгдэнэ.

Гэхдээ дараа нь төсвөө бид хэлэлцэх үед Үндсэн хуулийнх нь зарчмын дагуу бид зөвхөн орлогоо нэмж болно. Харин зарлагаа нэмж болохгүй болно.

Ингэхээр өөрөөр хэлбэл батлах гэж байгаа төсөв маань өөрөө төсвийн хүрээний мэдэгдэлдээ нийцсэн байх ёстой гэдэг энэ шаардлага маань хангагдахгүй байх ийм эрсдэл байна л гэж танд хэлж байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Хариулт хангалтгүй гэж үзэж Л.Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболдж: Тэгэхээр харин одоо манай хамтарсан Байнгын хороо маань эндээс ямар шийдвэр гаргах вэ гэдэг асуудлаас болоод Төсвийн прокурорын зөвлөлийн дүгнэлт гаргах юм байна.

Сангийн яамны тайлбар бол зөвхөн орлого талаа өсгөж болно, зарлага талаас нэмж болохгүй гэдэг ийм юу гаргаж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр бид санал хураах дээр. Санал хураах юм байхгүй зөвхөн танилцах юм уу, сонсох юм уу? Тийм ээ. Тэгвэл энэ дээр зүгээр ер нь цаашдаа яах вэ л гэдэг л асуудал гарах юм байна даа. Нэгдсэн хуралдаан дээр л очиж байж шийдэгдэх үү. Тийм ээ.

Р.Сэддорж: Л.Соронзонболд гишүүн бол бас яг тулгамдсан асуудлыг ярьж байна. Нэгдсэн хуралдаан дээр очиж буцаах эсэхийг шийдэх юм байна.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Өдрийн мэнд хүргэе.

Төсвийн хүрээ хэлэлцэж байна. Надад нэг асуулт байна. Энэ инфляцыг бид ерөөсөө яагаад дандаа бууруулж чадахгүй байна. Энэ жил 7.5 болоод бүр өсөөд ороод ирлээ шүү дээ.

Тэгээд одоо цалин хөлсөө нэмнэ гээд л иргэд маань жагсаад байна. Бид цалин хөлсөө нэмж чадахгүй л суугаад байна. Хангалттай. Үгүй ээ, ядаад энэ тавьж байгаа цалин хөлс маань инфляцад идэгддэггүй баймаар байна. 2019 оноос хойш инфляцад 20 хувь идэгдэж байгаа байхгүй юу. Энэ хүмүүст тавьж байгаа цалин маань.

Тэгэхээр Монголбанкнаас өнөөдөр энд байна уу? Монголбанк ер нь бодлогын хүүгээ өсгөхөөс өөрөөр ер нь энэ инфляцыг бууруулах ямар арга хэмжээ хэрэглэдэг юм бэ?

Төрийн өмчийн компаниуд гээд сүүлийн үед нэг маш том орлоготой, зарлагатай байгууллагууд бий боллоо шүү дээ. Жилдээ 16-аас 20 их наядын зарлагыг бий болгож байна. Тэгээд маш их өндөр өртөгтэй төрийн мөнгөөр үнэ хамаагүй худалдаж аваад л инфляц хөөрөгдөөд байдаг. Тэд нар чинь л мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлээд байгаа байхгүй юу. Түүнээс биш арилжааны банкнууд бага хүүтэй зээл өгөөд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байгаа юм биш.

Тэгэхээр Монголбанкны зүгээс инфляцыг бууруулах арай өөр аргачлал хэрэглэхгүй бол аж ахуйн нэгж, зах зээл чинь бүр агшаад байхгүй болох гээд байна.

Хоёрдугаар асуулт нь, Сангийн яамнаас асуулт асуух гээд байгаа юм. Дахиад төрийн өмчийн компаниудтай холбоотой. Уул уурхайн төрийн өмчийн хэдэн компаниуд байдаг юм бэ? Эдгээр компаниудаас авах орлогоо дутуу аваад байгаа юм биш биз дээ. Яагаад гэхээр энэ жилийн ногдол ашиг хэлбэрээр авах дүн маань багаар төлөвлөгдсөн байна. Уул уурхайгаа бага олборлоно гэж баймааргүй юм. Олборлолтын хэмжээ буураагүй л байлтай. Тэгтэл ногдол ашгийн хэмжээ буурсан байгаа юм. Энэ юутай холбоотой юм бэ?

Хоёрдугаарт нь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг хэдэн төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд байна вэ гэдэг асуулт. Цаашлаад нэмэгдсэн өртгийн албан татвар дээр нэг асуулт байна л даа. Нийт уул уурхайн компаниуд маань ер нь НӨАТ хэдий хэмжээний НӨАТ төлдөг юм? Нийт НӨАТ төлөгчдийн хэдэн хувийг нь уул уурхайн компаниуд эзэлдэг юм бэ гэдэг энэ асуултад хариулт авъя.

Р.Сэддорж: Н.Ургамалсувд байна уу? 7 номер.

Н.Ургамалсувд: Монголбанкнаас Н.Ургамалсувд.

Өнгөрсөн арваад жилийн статистик мэдээллээс харах юм бол инфляцын задаргааг задлаад харахаар 60 хувь орчим нь Байнгын нийлүүлэлтийн шалтгаантай инфляцаар тайлбарлагдаж байгаа.

Тэгэхээр Монголбанкны бодлогын хэрэгсэл бүгдээрээ эрэлтийн шалтгаантай инфляц буюу дотоод эрэлт, нийт эрэлтийг нөлөөлөх замаар инфляцыг удирдах ийм бодлогын хэрэгслүүдтэй байдаг.

Харин нийлүүлэлтийн шалтгаантай инфляцтай нийлүүлэлт, бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хангамжийг сайжруулах, ложистик бүтцийг

сайжруулах, дэд бүтцийг сайжруулах зэргээр салбарын яамд үүнийг хариуцдаг ийм ажил байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Бид нарын төсөөллөөр яах вэ инфляц энэ онд манай зорилтот түвшний дээд хязгаарт хүрнэ. Ирэх оны эхний хагаст инфляц тэгж хурдан буурахааргүй байгаа. Харин сүүлийн хагас руугаа буурах ийм төсөөлөлтэй байгаа.

Р.Сэддорж: Сангийн яам. 9 номер.

М.Санжаадорж: Сангийн яам М.Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя.

Ногдол ашгийн хувьд “Эрдэнэс Монгол” компанийн харьяанд уул уурхайн компаниуд нийцтэй. Уул уурхай болон тээврийн компаниуд нийлээд 17 компани ажиллаж байгаа. Эдгээр компаниудаас бид төрийн өмчтэй 7 компани ногдол ашиг ирэх жил орлого төвлөрүүлэхээр тооцсон байгаа.

Ногдол ашгийг мэдээж хэрэг гарч ирж байгаа ашгаас нь өмнөх жилийн ашиг буюу 2025 онд энэ жилийн ажилласан ашгаас нь ирэх жил хуваарилна.

Тэгэхээр мэдээж хэрэг үүнд тэр гаргаж байгаа бүтээгдэхүүнийхээ хэмжээ, үнэ шалтгаалж байгаа.

Ногдол ашгийн төлөвлөгөөг бид гаргахдаа хариуцсан газар болох Төрийн өмчийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан ёсоор бичгийг нь аваад ирэх жилийн бизнес төлөвлөгөөтэй нь уялдуулаад, ногдуулаад тавьж байгаа.

Ер нь уул уурхайгаас авч байгаа бид нарын орлогын хэмжээ гэх юм бол нийт орлогын маань 30 орчим хувь байгаа. Энэ дотор аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 3.2 их наяд төгрөгийг уул уурхайгаас... /минут дуусав/

Р.Сэддорж: 9 номер гүйцээж хариулъя.

М.Санжаадорж: Ирэх жилийн хувьд уул уурхайн салбараас бид аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 3.2 их наяд төгрөгийг зөвхөн уул уурхайн салбараас олно гэсэн ийм тооцоололтой байгаа.

Уул уурхайн бус салбараас 3.3. Ингээд нийлээд 6.5 их наяд төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг тооцож, орлогыг тооцож тавьсан байгаа. Тийм. Баярлалаа.

Р.Сэддорж: Б.Пунсалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Пунсалмаа: Тэгэхээр Монголбанк сүүлийн хагас жил рүүгээ инфляцыг бууруулна гэж хэллээ. Хэдэн хувь хүртэл бууруулах бололцоотой юм бэ?

Хоёрдугаарт нь, төрийн өмчийн нийт хэдэн уул уурхайн компаниуд байна гэдэг тэр тоо. Тэрнээс ашигтай ажиллаж байгаа нь 7 компани байна гэж ойлгож болох уу?

Цаашлаад уул уурхайн орлого нь нийт төсвийн 30 хувийг эзэлж байгаа юм уу? Тийм ээ. Уул уурхай экспортын 90-ээд хувийг эзэлж байгаа. Төсөвт 30-аад хувийн орлого, төсөв бүрдүүлдэг гэж ойлгож болох уу?

Тэгээд энэ талаар би ер нь бичгээр Та бүгдээс бас хариултыг нь авъя гэж бодож байна. Сангийн яамнаас.

Р.Сэддорж: Хэн хариулах вэ? 7.

Н.Ургамалсүвд: Тийм. Бид өргөн барьсан төсвийн төсөөллөөр авч үзээд тооцооллоо хийсэн байгаа. Тэгэхэд ирэх оны эцэс гэхэд инфляц 7 орчим хувь, 7-гоос арай бага хувьтай болохоор байгаа гэсэн ийм тооцоололтой байгаа.

Р.Сэддорж: 4 номер нэмж хариулъя.

И.Батхүү: Б.Пунсалмаа гишүүний асуултад нэмэлтээр мэдээлэл өгье.

2026 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл дээр сая дурдсантай адилхан ирэх оны инфляцын түвшнийг 7 хувиар зорилтот түвшин байсан. Сая санал хураагдсан томьёоллын дагуу эдийн засгийн холбогдох тооцооллын, дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооллыг хийж оруулах үүрэг өгөгдсөн байна.

Үүний дагуу тооцоолол хийхэд нэгдүгээрт инфляцын түвшин маань өрхийн орлогын хэмжээ нэмэгдэх, эрэлтийг нэмэгдэхээс шалтгаалаад 0.5 нэгж хувиар нэмэгдэх нөлөөлөл байгаа. Үүнтэй холбоотой 7.5 хувь гэж өөрчлөгдсөн байгаа.

Хоёрдугаарт нь, төсвийн хүрээний мэдэгдэл дээр холбогдох тооцооллыг нь гаргахад нэгдсэн төсвийн суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ нь 1.9 хувь болсон байгаа.

Хуулиар тусгай шаардлага нь 2 хувь байдаг. Үүнээсээ доошоо буусан байгаа гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны гишүүд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд баярлалаа.

Хуралдаан 22 минут үргэлжилж, 14 цаг 03 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД